



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/Б/12

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.11 дэх заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд Газар эзэмшил, өмчлөл, ашиглалттай холбоотой маргаан өргөдөл, гомдолтой холбоотой асуудлыг хэлэлцэж, холбогдогч этгээдүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн

Дарга: Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Нарийн

бичиг:

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого,
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүйн
хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ
үнэлгээний хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын, Хөгжлийн бодлого
төлөвлөлт, Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, орон сууц
газрын харилцааны бодлого хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Ерөнхий архитектор

Тухайн сумын Засаг дарга нар

2.Ажлын хэсгийг сар тутам хуралдуулж газрын өргөдөл, гомдол, маргаантай холбоотой асуудлыг хэлэлцэж, зохион байгуулах, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга бөгөөд ажлын хэсгийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\Захирамж-2024

231010783